



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 5/10

Эг

Сумын Засаг даргын орлогчоор Б.Төрмөнхийг
түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.22, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Болдын Төрмөнхийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс сумын Засаг даргын орлогчоор түр томилсугай.
2. Б.Төрмөнхийн үндсэн цалинг 1,870,000 (нэг сая найман зуун далан мянган) төгрөг, онцгой нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар, хоол унааны зардлыг ажлын өдөр бүр 10,000 (арван мянган) төгрөгөөр тус тус тооцон олгохыг нягтлан бодогч (Б.Минжинсор)-т зөвшөөрсүгэй.
3. Б.Төрмөнхөд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт гарган өгч хянуулахыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

202401019